

СЭТГҮҮЛ ЗҮЙН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ
ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Л.Норовсүрэн*, Б.Энхчимэг**

* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D)

** МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант

Түлхүүр үг: сэтгүүл зүй, тодорхойлолт, шалтгаан, үзэгдэл, хүмүүнлэгийн ухаан, эмпирик арга, соёл, үнэлэмж, тогтолцоо, онол, арга зүй, орон зай, шинжлэх ухаан, хуурамч ухамсар

Улс орон ардчилсан тогтолцоонд шилжин орж, нээлттэй бодлого явуулах болсон өнөө үед нийгмийн шинжлэх ухаан, түүний олон салбарт шинээр сэтгэх хийгээд асуудалд шүүмжлэлт уур амьсгалаар хандах явдал хэм хэмжээ болж байгаа билээ. Сэтгүүл зүйн хүрээ ч энэ хандлагын гадна байсангүй. Сэтгүүл зүйн уламжлалт үүрэг, зарчим, үйл ажиллагааны арга зүйд ч эргэлтийн шинжтэй өөрчлөлтүүд гарсан юм. Сэтгүүл зүй бол олон нийтэд хэрэгтэй чухал мэдээллийг цуглуулж, боловсруулж, түгээх нийгэм улс төрийн үйл ажиллагааны хэлбэр гэж үздэг бидний уламжлалт тодорхойлолт ч шинэ агуулгаар баяжиж байна. Сэтгүүл зүйн тухай тодорхойлолт бидний дурдсаанаар хязгаарлагдахгүй олон янз байдаг. Энэ нь тэдгээрийг томъёолсон зохиогчдын дутуу хагас бодож

боловсруулснаас шалтгаалдаг биш, харин хөгжлийн өөр өөр үед, улс орон бүрд сэтгүүл зүй үүсч хөгжсөн онцлогийн аль нэгний шинж чанар, туршлагад тулгуурласнаас болдог. Сэтгүүл зүйн онолын тодорхойлолтууд нь сэтгүүл зүйн ухаан үүсч, оршиж, бас нотлогдож юм уу няцаагдаж байх олон талын аль нэгийг, эсвэл заримыг онцлох замаар буй болсон байдаг. Иймд тэдгээр тодорхойлолт хоорондоо зөрчилдөх биш, харин бие биеэ баяжуулж, бусдынхаа дутууг нөхөх харилцаанд оршдог.

Түүний зэрэгцээгээр ерөөсөө сэтгүүл зүй шинжлэх ухаан, сэтгүүлч мэргэжил мөн үү, түүнчилэн сэтгүүл зүй шинжлэх ухаан юм уу, хүмүүнлэгийн мэдлэг юм уу? гэх мэт олон асуултыг ахуйн хүрээнд төдийгүй судалгаа шинжилгээний түвшинд хөндөж тавих болов. Ийм асуултад хариулахад дөхөм болох санаа эдүгээгээс өмнөх үеийн улс төр, гүн ухааны сонгодог онолчдын бүтээлд ч тэмдэглэгдсэн байдаг. Жишээ нь К.Маркс, Ф.Энгельс нар «Германы үзэл суртал» гэдэг зохиолдоо хүний хөгжлийн өндөр түвшинд хүрсэн үед авьяас чадвар шаардсан мэргэжлүүд

устана гэсэн санааг хэлж байжээ. Үнэхээр ч өнөөдөр уран зургийн сургууль төгсөөгүй хэрнээ мэргэжлийн зураачаас дутахгүй зурдаг, хөгжмийн боловсрол эзэмшээгүй атлаа номыг нь үзсэн хүмүүсээс илүү сайхан ая дуу зохиодог авьяастнууд олон болсон. Энэ мэтээр үнэхээр хөгжсөн, оюунлаг, авьяаслаг хүмүүсийн хийж чадаж байгаа ажлын нэг бол сэтгүүлч юм. Өнөөдөр Монголын хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсдын гуравны хоёр нь сэтгүүлч биш хүмүүс байна. Тэдний дотор мэргэжлийн сэтгүүлчдийг ичээхүйц бичдэг, редакторладаг уран бүтээлч, хэвлэл мэдээллийн чадварлаг менежер олон байгаа юм.

Сэтгүүл зүйн философи бол сэтгүүл зүйн үйл ажиллагааны олон талын аль нэгийг юм уу, эсвэл зарим хэсгийг онцлон авч үзээд хэвлэл мэдээллийн салбарын өөр өөр төрөл, дор хаяж аль нэг чиглэлийг бүхэлд нь, эсвэл үйл ажиллагааны нь аль нэг талд хүчинтэй байх тодорхой онолуудыг боловсруулдаг салангид сургаалуудын цогц мөн. Сэтгүүл зүйн үйл ажиллагаа нь материаллаг ба сэтгэллэг, ерийн ухамсар ба онолд тулгуурласан, сэтгэхүй ба мэдрэмжийг чухалчилдаг зэрэг нэн олон талтай байдаг. Тэдгээрийн аль нэгэд юм уу, зарим хэсэгт үнэлэмжийн өөр өөр онолын дүгнэлт өгөх замаар сэтгүүл зүйн философийн чиглэлүүд үүсдэг. Эдгээр чиглэлийн нэг хэсэг нь сэтгүүл зүйг шинжлэх ухаан гэж үзэх философийн чиглэлд хүчинтэй байхад, нөгөө зарим нь сэтгүүл зүйн онолын бүх чиглэлд хүчинтэй байж чадах интеграль ач холбогдолтой юм. Чиглэлүүдийн интеграль шинж нь чухам ямар үндэслэлд суурилснаас шалтгаалдаг.

Сэтгүүл зүй нь шинжлэх ухаан, хүмүүнлэгийн онол хоёрын судалгааны

объект нэгэн зэрэг болох нь хэвийн үзэгдэл юм. Бид үзэгдэл үйл явдлыг танин мэдэх зорилт тавиад үр дүнд нь буюу үнэн гэж тооцсон мэдлэгтээ үнэлгээ өгч, нөгөө талаар үнэлэмжийн үр дүн болсон сайхан муухай, ашигтай ашиггүй, шударга шударга биш гэх мэт мэдлэгийнхээ үүднээс тухайн үйл явдал, үзэгдлийг танин мэдэх зорилтоо, түүний дотор шинжлэх ухааны судалгаагаа хэрхэхийг шийддэг. Энд үнэлэмжийн үр дүн болж гарч ирдэг онолыг хүмүүнлэгийн онол, хүмүүнлэгийн ухаан гэх мэтээр нэрлэх явдал онолын салбарт хэвшсэн зүйл юм.

Үнэлэмжийг онолын түвшинд илэрхийлснийг хүмүүнлэгийн ухаан гэдэг. К.Маркс эдийн засгийн хууль, зүй тогтлыг өмнөх ба өнөөг судалж байж гаргаж ирсэн боловч тэр судалгаагаа гагцхүү капитализмыг устгах, түүнийг шулан мөлжигч гэж харуулах зорилгоор тайлбарлаж, түүндээ хөтлөгдсөн нь үнэлэмжийн мэдлэг болсон байдаг. Түүнтэй адил коммунист сэтгүүл зүйг нийгэмд гүйцэтгэх үүргийнх нь хувьд дан ганц үзэл суртлын зэвсэг, эрх баригч намын дуу хоолой болох талаас нь үнэлэх, үйл ажиллагааг нь цагдан хяналтын буулга дор өөрөөр сэтгэх, шүүмжлэлтэй хандах эрхээ хязгаарлуулсан хоосон магтаал гэж нотлохыг оролдох нь сэтгүүл зүйн хуримтлуулсан туршлагыг үгүйсгэсэн өрөөсгөл үзэл болно. Тиймээс сэтгүүл зүй нь хувь сэтгүүлчийн үзэл бодлыг тулгадаг биш, харин янз бүрийн үзэл бодлуудыг дамжуулдаг үйл ажиллагаа байх ёстой.

Сэтгүүл зүй шинжлэх ухаан юм уу, хүмүүнлэгийн мэдлэг юм уу? гэдгийг нотлохын тулд дараах хоёр ялгааг анзаарах хэрэгтэй. Үүнд шинжлэх ухаан бол үзэгдлүүдийн шалтгаан, мөн чанарыг нээх зорилт дэвшүүлээд, үр

дүнд нь тэдгээрийн дараалал ба давтагдагч төсөөтэй шинжүүдийг эмхлэн цэгцэлдэг мэдлэгийн тогтолцоо мөн. Тэгэхдээ юмсын үүссэн, хөгжсөн, устсан хийгээд тэдгээрийн орон зай, цаг хугацаа зэргийг тогтоох замаар буй болдог мэдлэг юм. Тиймээс ч Гегель юмны мөн чанарыг нээх нь шинжлэх ухааны зорилго гэсэн байдаг. Гэтэл хүмүүнлэгийн ухаан нь эмпирик аргуудыг ашиглан нийгмийн амьдралын үзэгдлүүдийн үүссэн дараалал ба давтагдагч төсөөг тогтоосон, өөрөөр хэлбэл танин мэдэхүйн үр дүн, нөгөө хэсэг нь үнэлэмжийн, тодруулж хэлбэл нийгмийг танин мэдсэн үр дүнд үнэлгээ өгч, утга оноож, тайлбар хийж байдаг онцлогтой байна. Жишээ нь социализмын үеийн сэтгүүл зүйн мэдлэгт шинжлэх ухааны үр дүн ба үнэлэмжийн онолын шинж давтагдмал байж, зөвхөн үзэл суртал ноёрхсоор шинэ сэтгүүл зүйтэй золгожээ. Харин сүүлийн хорь гаруй жилд сэтгүүл зүй судлаачид тийм үзэл сурталжсан монист тайлбараас улам бүр татгалзсан судалгаа, сурталчилгаанд шилжсэн юм. Энэ бол өмнөх үетэй харьцуулахад том дэвшил мөн.

Орчин үеийн сэтгүүл зүйн судалгаанд голч байр сууринаас бодитой хандахад судлаачдын нийгмийн баримжаа чухал үүрэгтэй юм. Амьдрал дээр сэтгүүлчийн байр суурь нэг тохиолдолд нийгмийн бүх асуудлыг тал бүрээс нь системтэй хамарсан, чиглэсэн зорилготой, нарийн нягт боловсруулагдсан байхад, нөгөө тохиолдолд тодорхой дэс дараагүй, үндэслэл муутай, асуудалд өнгөцхөн хандсан, бүрэн илэрхийлж чадаагүй байх нь бий. Гэхдээ аль ч тохиолдолд байр суурь нь анги, үндэстэн, бүс нутаг, эсвэл нам, эвсэл, холбоо гэх мэт нийгмийн тодорхой хүчний эрх ашгийг хамгаалах,

төлөөлөхийн илрэл болохын хувьд нийгмийн амьдралд хандах хандлага, өгөх үнэлэлт дүгнэлт, улс төр, эдийн засаг, эрх зүйн хүрээнд гаргах шийдвэр, санал зөвлөмжийн шинж чанарыг тодорхойлж байдаг.

Олон хэсэг, бүлгээс бүрдсэн нарийн зохион байгуулалт бүхий орчин үеийн нийгэмд тулгамдсан бүх асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг зүйл бол хүний үнэт зүйлс юм. Учир нь энэхүү үнэт зүйлс хүмүүсийг нэгтгэж, нийгмийн янз бүрийн хүрээнийхний зан байдал, үйл ажиллагааны ерөнхий дүр төрхийг буй болгож байдаг. «Хүн төрөлхтний үнэт зүйлс нь энх тайван, сайн хөршийн харилцаа, хүч үл хэрэглэх, хүлээцтэй хандах гэх мэт дэлхий дахиныг хамарсан томоохон асуудлуудаас эхлээд шударга байдал, эв нэгдэл, эмх цэгц, уян хатан, даруу төлөв гэх зэрэг ахуй амьдралын асуудлыг хүртэлх янз бүрийн хүрээ, түвшний зүйлийг агуулж байдаг. Эдгээр үнэт зүйлс сэтгүүлчийн нийгмийн байр суурийг бүрдүүлж байдаг хэргийн учир оршино. Гэхдээ сэтгүүл зүй нийгмийн амьдралд дүн шинжилгээ хийх, тунгаан бодох, үнэлж дүгнэх явцад хүн төрөлхтний үнэт зүйлсийг хэлбэрэлтгүй мөрдөхөд бэрхшээл тулгарах нь зайлшгүй.

Энэ нь нэгдүгээрт: үнэт зүйл бүхэн сэтгүүлчийн байр суурьтай тохирч байх албагүй, хоёрдугаарт: хувь хүн бүр өөрийн анги бүлэг, үндэс угсаа, нутаг дэвсгэр, мэргэжил боловсрол, хүсэл сонирхол зэргээсээ шалтгаалан эрхэмлэх үнэт зүйлс нь адилгүй байдагтай холбоотой юм»¹. Ийм байдал нь сэтгүүл зүйг мэргэжил гэхээсээ үнэлэмжийн мэдлэг гэх нь илүү оновчтой мэт санагддаг. Жишээ нь оюун ухаан нь хэчнээн их хөгжсөн, ямар ч авьяастай байлаа гээд дурын хүн эмчийг шууд

орлож чадахгүй. Нөгөө талаар хүнд тусдаг өвчин нийгмийн анги бүлэг, үндэс угсаа, тухайн өвчтөний үзэл бодол, үнэт зүйлсээс үл хамааран нийтлэг шинж тэмдэг, эмчилгээний аргатай байдаг. Иймээс эмчид үнэлэмжийн мэдлэг бус шинжлэх ухааны мэдлэг, туршлага хэрэгтэй учир анагаах эрдэм нь шинжлэх ухаан, жинхэнэ мэргэжил болж байх жишээтэй.

Бид сэтгүүл зүйн мэдлэгийн тухай ярихдаа нэг зүйлд ялгавартай хандах хэрэгтэй юм. Тэр нь нэгд: сэтгүүл зүйг шинжлэх ухаан, хүмүүнлэгийн мэдлэг, тэр дундаа үнэлэмжийн мэдлэгийн аль нь гэж үзсэнээс үл хамааран түүний дотоод мөн чанарын гэж болох онолын мэдлэг, хоёрт: сэтгүүл зүйн өдөр тутмын үйл ажиллагааны явцад нийтлэл, нэвтрүүлгээр нь дамжиж буй болдог мэдлэг юм. Энэ хоёр төрлийн мэдлэгийн хоёр дахид үнэлэмж давамгайлж байдаг нь хэнд ч ойлгомжтой бөгөөд, ийм байх нь сэтгүүл зүйн практик ажиллагааны зорилго юм. Барууны нэр хүндтэй зарим сэтгэгчдийн үзэж байгаагаар хүний бодгал сэтгэлгээний талбарыг *оюун ухаан*, концепт бүтээхийг *оюун бодол*, ойлголт бүтээгчийн урлахуйг *ургуулан бодох*² гэж томъёолсон байдаг. Сэтгүүл зүйн мэдлэгийг бүтээхэд эдгээр аргыг бүхлээр нь буюу заримыг хэрэглэж хэвшсэн юм.

Орчин үед мэдлэгийн төрлүүд дотроос шинжлэх ухааныг л дээдэлж, бүхнийг шинжлэх ухаанаар удирдах тухай ярьж, бичих болов. Үнэхээр

орчин үеийн иргэншил шинжлэх ухаангүйгээр төлөвшихгүй нь үнэн. Гэвч урлаг, гоо зүй, түүх, ёс суртахууны сургаал, сэтгүүл зүй зэрэг хүмүүнлэгийн онол, үзлийн үнэ цэнг үл тоомсорлож болохгүй билээ. Шинжлэх ухаан техникийн тэргүүлэх салбар гэж яриад, хүмүүжлийн мэдлэгийг гадуурхах төрийн бодлого явж эхэлсэн нь ч ил тод болсон зүйл. Гэтэл хэн ч гэсэн гэр бүл, сургалт, хүмүүжил, соёлын, түүний дотор сэтгүүл зүйн идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд л хүмүүнлэгийн мэдлэгээр сэтгэл оюунаа тэжээж, зөөл-

лөж байж шинжлэх ухааны шимийг хүртэх учиртай билээ. «Чухамхүү хүмүүнлэгийн боловсролгүй хүмүүс л бэртэгчин зорилгоор жолоодуулсан чулуун зүрхтэй шуналын туламнууд болж төлөвшдөг гэх нь айхтар нээлт хийсэн үг биш, харин амьдралд ил тод байгаа

«

***Коммунист сэтгүүл зүйн үед
хэвлэл мэдээллийн хэрэгсэл үзэл
суртлын зэвсэг болж, сэтгүүлч
нийтлэлчдийн үзэл бодлоо
чөлөөтэй илэрхийлэх эрхийг
боогдуулсан цагдан хяналтын дор
үйл ажиллагаагаа явуулж байсан
нь тухайн сэтгүүл зүйн
дутагдалтай тал мөн***

»

баримт. Өнөөгийн монголчууд газар нутгаа хайрлан хамгаалж, эзэмшиж, ашиглаж ирсэн өвөг дээдсийнхээ уламжлалыг хөсөр хаяж, улмаар харийнхны тусламжтайгаар сэндийчийн шуналаа барьж үл дийлэн, үүний уршгаар уул маань тал, тал маань там, ус нуур маань шалбааг юм уу, хатсан хонхор болж, улс оронд минь баян хоосны ялгаа гүнзгийрч байгаагийн гол буруутан нь улс төрийн болон эдийн засгийн салбар дахь чулуун зүрхтэй, технократ үзэлтэй янз бүрийн шатны эрх мэдэлтнүүд, тэдэнтэй сүлбэлдсэн дотоод, гадаадын хамсаатнууд гэдгийг манай зарим иргэд, шударга эрдэмтэд, сэтгүүлчид илчилсээр»³ байгааг ном

бүтээлд дурдсан бий. Энэчлэн технократ онол, шийдвэр, практикийн хахир хатуу төдийгүй, олон тохиолдолд бэртэгчин зорилтыг засахад хүмүүнлэгийн мэдлэг, түүний дотор сэтгүүл зүйн үйл ажиллагаа өөрийн онцлог бүхий хувь нэмрийг оруулж байдаг.

Шинжлэх ухааны үүднээс хангалттай үндэслэл бүхий дүгнэлт хийж болохгүй байгаа тийм хүрээний түүхэн мэдлэг, тайлбарыг үнэлэмж үү, үзэл суртал уу? гэж ялгахад бэрх юм. Тухайлбал түүхэнд гүнзгий ул мөр үлдээсэн коммунист сэтгүүл зүйн аль нэг талд нь байсан дутагдал, өөр нэг талынх нь гавьяа хоёрыг зэрэгцүүлэн мэдээлэхэд хүрвэл тэр нь танин мэдэхүйн үр дүн болно. Тухай тухайн үйлдэлд нь харгалзуулж уг сэтгүүл зүйг сайн, муу гэж үнэлэх нь байж болох үйлдэл юм. Харин тэдгээр өөр өөр үнэлгээний аль нэгийг хөдөлбөргүй үнэн мэтээр туйлчилж, түүгээрээ бусад талд нь хамаарах ялгаатай үнэлгээнүүдийг дарангуйлбал үзэл суртал буюу хуурамч ухамсрыг буй болгодог. Дурдан буй үеийн Монголын хэвлэл мэдээллийн томоохон хэрэгслүүд, тэдгээрийн зүтгэлтнүүдэд бидний өгдөг үнэлгээ, тэдгээртэй холбоотой өрнөж байгаа түүхэн ба онолын маргаанаас ийм дүгнэлт хийж болно. Аль ч үеийн сэтгүүл зүйн практикт тийм хуурамч ухамсар бүтээх явдал байсаар ирснийг түүх гэрчлэх юм. Жишээ нь коммунист сэтгүүл зүйн үед хэвлэл мэдээллийн хэрэгсэл үзэл суртлын зэвсэг болж, сэтгүүлч нийтлэлчдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг боогдуулсан цагдан хяналтын дор үйл ажиллагаагаа явуулж байсан нь тухайн сэтгүүл зүйн дутагдалтай тал мөн. Гэтэл үүгээр коммунист сэтгүүл зүйн үед Монголын олон нийтийн мэдээл-

лийн хэрэгслийн цогц систем бүрэлдэн тогтож, сэтгүүл зүйн туурвилын олон арга хэлбэр төлөвшин бүрэлдэж, мэргэжлийн сэтгүүлчдийн хэд хэдэн үе өсч бойжсон түүхэн ололтыг баллуурдаж болохгүй билээ.


Түүнчилэн социализмын үед Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал нарыг Монголын ард түмний шалгарсан удирдагч хэмээн тэнгэрт тултал магтаж, үг сургаалыг нь найман настай балчраас наян настай буурлууд хүртэл нийт ард түмнээр цээжлүүлж, тахин шүтэхэд чухал үүрэг гүйцэтгэж байсан шигээ нийгмийн шилжилтийн дараа тэднийг газар доогуур ортол харааж зүхэхэд сэтгүүл зүй мөн л тэргүүн эгнээнд нь явсныг мартаж болоогүй байна. Цаг дагаж, эрх мэдэл дагаж хувирч байдаг шинжлэх ухаан байдаггүй байх. Харин үнэлэмж байж болох юм. Ингэхээр сэтгүүл зүй бол бодит байдлыг танин мэдэхээсээ илүү нэгэнт танигдсан мэдлэгт олон ургальч үнэлгээ өгдөг үйл ажиллагаа байж иржээ. Жишээ нь капиталист байгуулал нийгмийн хөгжлийг түргэсгэдэг нь ямар учиртай вэ, социалист нийгэм юунаас болж мухардалд оров? гэх мэтийг шинжлэх ухаан танин мэддэг бол, сэтгүүл зүй тэр мэдлэгт аль нэг талаас нь үнэлгээ өгч үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ шинжээрээ сэтгүүл зүй нь хүмүүнлэгийн мэдлэгийг бүтээж байдаг гэж үзүүштэй юм. Дээр жишээлсэнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түүнд ажиллагч сэтгүүлчид түүхэн хүн хийгээд үйл явдал, түүнчилэн орчин үеийн асуудалд өөр өөр үнэлгээ, дүгнэлт хийдэг нь сэтгүүл зүйг хүмүүнлэгийн мэдлэгийн шинжтэй болгож байдаг.

Сэтгүүл зүйг хүмүүнлэгийн мэдлэгт ойртуулж буй бас нэг шинж нь үндэсний онцлог юм. Жинхэнэ

шинжлэх ухаанд, тухайлбал биологийн ухаанд Америкийн биологи, Хятадын биологи гэж байдаггүй. Тэр нь байгалийн зүй тогтлыг нээж, танин мэдэх нэг л аргатай байдаг. Гэтэл сэтгүүл зүйд нэг талаас дэлхий дахины сэтгүүл зүйн номлол, арга барилыг ашигладаг боловч, нөгөө талдаа зөвхөн үндэстэн дотроо хүчинтэй байдаг онол номлол, үндэсний өвөрмөц онцлогууд агуулагдаж байдаг. Ийм ялгаа тухайн үндэстний хэл, соёл, шашин, зан заншлын өвөрмөц байдлаас үүсэлтэй юм. Ерөөсөө тухайн ард түмний түүхэн тодорхой нөхцөлд соёлын зарим төрөл амжилттай хөгжиж, бусад нь сул хөгжилтэй юм уу, огт хөгжөөгүй байх нь тэр ард түмний дутагдлаас биш, харин амьдрал үйл ажиллагааных нь онцлогоос хамаардаг аж. Үнэн хэрэгтээ Монголын сэтгүүл зүйн өнөөдрийг хүртэлх мэдлэг танин мэдэхүйн шаргуу судалгаа, туршилтын үр дүн болж бүрэлдсэн нь харьцангуй бага юм. Энэ салбарын мэдлэг бүхэлдээ өөр ухаануудын эмпирик судалгаагаар танин мэдэгдсэн мэдлэг дээр суурилж, түүнд үнэлгээ өгөх замаар хөгжиж ирсэн байдаг. Жишээ нь Монголын сэтгүүл зүй ном хэвлэж барлаж ирсэн арвин туршлага, олон үеийн туршид бүтээгдсэн утга зохиолын төрөл зүйл, дэлхийн улс орнуудаас тогтмол хэвлэл гаргаж ирсэн туршлага, тэдгээрт ажиллаж дадлагажсан сэхээтнүүдийн чадвар зэрэг нэгэнт танигдсан мэдлэг туршлагад тулгуурлан үүсч, хөгжсөн байна.

Сэтгүүл зүйг бас соёлыг бүтээх үйл ажиллагаа гэж үзэх хандлага бий. Сэтгэгч Гегелийн томьёолсныг үндэслэвэл сэтгүүл зүй нь соёл соёлдоо бүр дээд соёл болох аж. Тэрээр хүчтэний хууль ноёрхдог хамтлагаас иргэний нийгэмд, эрх зүйт төрд шилжих үе буюу

бодгал хүн ёс суртахуунаас зан суртахуунд шилжих явцад дээд соёл буй болдог гэсэн санааг хэлсэн юм. Монгол улс хүмүүнлэг ардчилсан нийгэм байгуулж, нийгмийн бүх хүрээг гагцхүү хуулиар зохицуулдаг болсон. Ийм нөхцөлд сэтгүүл зүй нь нийгмийг хэрэгцээт мэдээллээр хангахын зэрэгцээгээр хүнлэг ёс, шударга байдал, тэгш эрхийг сахиулагч дээд соёл, хүн чанарын илэрхийлэл болох зүй тогтолтой юм.



нөөдөр сэтгүүл зүйд, ялангуяа судалгааны салбарт ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн дунд сэтгүүл зүйн өмнөх хэв маягуудыг бүхэлд нь хараар будах сэтгэлгээ нэлээд давамгайлах болсон. Ийм хандлагын үр хөврөл бүр эрт тавигдсан юм. Коммунист сэтгүүл зүйн үед 1921 оноос өмнөх хэвлэл мэдээллийн хэрэгсэлд “феодалын нийгмийнх” гэсэн пайз зүүж сургалт, судалгааны гадна орхидог байсан бол, өнөө үеийнхэн 1991 оноос өмнөх сэтгүүл зүйг “үзэл сурталжсан сэтгүүл зүй”, “цензуртэй сэтгүүл зүй” гэх мэт нэр хоч өгч, тэдгээрт байгаа үнэт зүйл, арга туршлагыг хэрэгсэхгүй байгаа нь шинжлэх ухааны судалгаанд зайлшгүй субьектив дүгнэлт хийхэд хүргэж байгаа юм.

Сэтгүүлчдийн дотор сэтгүүл зүйн аль нэг чиглэл, туурвилын арга хэлбэрийг үүсгэгч, анхдагч, зохиогч болох эрмэлзэл цөөнгүй гардаг. Жишээ нь өөрийгөө Монголын сэтгүүл зүйд ярилцлага хэмээх бичлэгийн зүйлийг оруулж ирсэн, надаас өмнө Монголд олон улсын сэтгүүлч байгаагүй гэх мэтээр тунхаглагчид мэр сэр байдаг. Гэтэл түүх сөхөөд үзэхээр ярилцлагын хэлбэртэй утга зохиолын зүйл Монголын хуучны утга зохиолд хэдэн зуун жилийн өмнө үүсээд хөрсөндөө лавтай суучихсан байдаг. Монгол хүн аль

тэртээх гучаад онд өндөр хөгжилтэй хөрөнгөтөн оронд сэтгүүлчийн мэргэжил эзэмшээд Дэлхийн II дайны гал утаан дунд явж, эхлэхээс нь дуусах хүртэл сурвалжлаад, улмаар 1945 онд Америкийн Сан-Франциско хотод болсон НҮБ-ийг үүсгэн байгуулах анхны хуралдааны мэдээг дамжуулж байсан байдаг. Энэ мэт түүхэн үнэнийг үгүйсгэж өөрийгөө дөвийлгөх оролдлого нь сэтгүүл зүйн судалгаанд хортойн дээр, ишиг эврээ ургахаар эхийгээ мөргөхийн үлгэр юм.

Хүмүүнлэгийн ухааны үнэлэмж нь үндэстэн бүрт хүчинтэй байж чаддаггүй, зөвхөн тухайн үндэстний хүрээнд хүчинтэй байдаг. Энэ шалгуур дээр улс үндэстэн бүрийн сэтгүүл зүйг тавиад үзвэл нийлэх, зөрөх юм олон гарна. Жишээ нь Монголын сэтгүүл зүйн онол, арга барилын нэг хэсэг нь дэлхий нийтийн жишигт нийцэж байхад, нөгөө хэсэг нь үндэсний уламжлал, зан заншил, эрхэмнэл, утга соёлын онцлогтой уялдсан өвөрмөц зүйлээрээ ялгарч байдаг. Өөр хаа ч байдаггүй ийм онцлогийн тод жишээ нь Монголын сэтгүүл зүйн туурвилд уран сайхны арга барил нэвт шингэсэн байдаг явдал мөн. Энэ нь *нэгд*: Монголын ард түмний алив юмыг уран цэцнээр илэрхийлж, дүрлэг байдлаар сэтгэж, ярьж, бичдэг уламжлалтай, *хоёрт*: үндэсний сэтгүүл зүй үүссэн цагаас хойш олон арван жилийн туршид хэвлэл мэдээллийн гол гол хэрэгслүүдийн нийтлэлийн бодлогыг их төлөв зохиолчид тодорхойлж ирсэнтэй холбоотой юм. Түүнчилэн Монголын сэтгүүл зүйн сургалт, судалгаа практик үйл ажиллагаанаасаа бараг хагас зуун жилээр хоцорч энэ хугацаанд утга зохиолын авьяас чадвар бүхий үндэсний сэхээтнүүд сэтгүүл зүйг авч

явснаас үүдэлтэй билээ. Сэтгүүл зүйг шинжлэх биш, харин хүмүүнлэгийн мэдлэгт тулгуурлан хөгжиж байгаа нийгэм улс төрийн үйл ажиллагаа гэж үзэх нэг үндэслэл нь энэ юм.

Сэтгүүл зүйг хүмүүнлэгийн ухаан, үнэлэмжийн мэдлэг гэж үзэх бас нэг үндэс нь түүний тулгуур зарчим, нийгмийн үүрэг зөвхөн оршин байгаа нийгэм улс төрийн системд хүчинтэй байж, нийгэм өөрчлөгдөхөд даган хувирч байдаг оршино. Социалист үзэл ноёрхож байх үед Монголын сэтгүүл зүй намч, ангич, өндөр үзэл сурталч, пролетарийн интернационализмд үнэнч байх зарчимтай, хамтын ухуулагч, суртал нэвтрүүлэгч, зохион байгуулагчийн үүрэгтэй байв. Улс орон хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг жишгийг дагаж улс төрийн ардчилсан тогтолцоо, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр эдгээр үүрэг, зарчмын олонх нь үйлчлэх чадваргүй болсноор сэтгүүл зүй шинэ нийгмийн агуулгад нийцсэн шинэ үүрэг хүлээж, шинэ зарчмуудыг мөрдөх болсон билээ. Ингэхээр сэтгүүл зүйд шинжлэх ухаан шиг улс төр, нийгмийн байгууллаас үл хамааран зөвхөн судлагдахуунд чиглэдэг тогтолцоот шинж үгүй юм. Өөрөөр хэлбэл сэтгүүл зүйн эрхэмнэл нь оршин байгаа нийгэмдээ л хүчинтэй байна.

Сэтгүүл зүйг нийгмийн ухааны нэг салбар гэж үзсээр ирснийг үгүйсгэх аргагүй байдаг. Учир нь түүний тусган үзүүлдэг объект нь ч, судлагдахуун нь ч нийгмийн амьдрал юм. Гэтэл логик, ёс зүй, гоо зүй гэх мэт нийгмийн ухааны салбарууд өөрийн гэсэн хууль, категори, тэр нь нийгмийн үзэгдлийг танин мэдэх нэг ёсны удирдамж, арга зүй болж байдаг. Гэтэл сэтгүүл зүйд тийм нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хууль, категори байхгүй. Оросын эрдэмтэн

Е.П. Прохоров ерээд оны үеэс сэтгүүл зүйн категорийн тухай асуудлыг дэвшүүлж тавьсан юм. Тэрээр “олон нийтийн мэдээлэл” гэдэг ойлголтыг сэтгүүл зүйн төвийн категори гэж нэрлээд, түүнийг тойрсон олон ухагдахууны тоонд “эрх чөлөө”, “үүрэг”, “зарчим”, “үр нөлөө”, “ур чадвар” гэх мэтийг тоочсон байдаг. Гэвч түүнийг хүлээн зөвшөөрсөн нэгдмэл ойлголт одоо хүртэл байхгүй. Тэр тусмаа сэтгүүл зүйн олон жилийн уламжлалтай, өндөр хөгжилтэй өрнөдийн орнуудад категори гэх мэтийг огт хэлэлцдэггүй. Тэгээд ч сэтгүүл зүйд, нийгмийн шинжлэх ухааны нэг салбар, тухайлбал логикд мөрддөг шиг адилтгалын, зөрчилгүйн, хангалттай үндэслэлийн, гуравдахийг үгүйсгэх гэх мэт хууль байхгүй. Шинжлэх ухааны хууль, категориуд аль ч цаг үед тогтвортой үйлчилдэг бол сэтгүүл зүйд ямар ч нийгмийн байгууллын үед тэсвэртэй байдаг тийм хууль, категори үйлчлэх боломжгүй юм. Учир нь сэтгүүл зүйн үүрэг, зорилго, үйл ажиллагааны зарчим цагийн аясыг даган өөрчлөгдөж байдагт оршино. Өөрөөр хэлбэл сэтгүүл зүйн судалгааны объект үе үе, ялангуяа нийгмийн шилжилтийн үед огцом өөрчлөгдөж, түүнийг дагаад сэтгүүл зүйгээс нийгмийн амьдралыг үзэх үзэл, үнэлэмж, үнэт зүйл өөрчлөгдөж байдаг. Ийм шинж нь түүнийг шинжлэх ухаан гэж үзэхэд эргэлзээтэй болгож байгаа билээ. Ер нь сэтгүүл зүйг шинжлэх ухаан гэж үзэх нь социалист, коммунист байгууллын үед хүчтэй илэрч дэлгэрсэн үзэл бодол юм.

Аль ч хэв маягийн сэтгүүл зүйд үнэнийг өгүүлэх нь тэргүүн зэргийн зарчим гэж бид үздэг. Тэгэхээр энэ зарчмыг хангахад ч гэсэн үнэлэмжийн нэг хэлбэр болох тохирооны онолыг

харгалзах хэрэгтэй болдог. Энэ тухайд ерөнхийдөө бидний бодол санаа бодит байдалтай тохирч байхыг үнэн гэж үзэх хандлага нэлээд түгээмэл юм. Эртний сэтгэгч Платон «Тухайн юмыг өөртэй нь адилхан ярьж байвал үнэн, харин адилгүй ярьж байвал худал болно»⁴ гэсэн бол, Аристотель «Юм оршдоггүй буюу юм биш болдог нь худал, харин юм оршдог, юм биш оршдоггүй нь үнэн»⁵ гэсэн байдаг. Энэ нь юмс бол тэдгээрт өгсөн нэртэй тохирч байх ёстой гэсэн Кунзийн онолтой үндсэндээ адил юм.

Мэдлэг юунаас үүсдэг тухай хоёр баримтлал философийн түүхэнд хамгийн их нөлөөтэй байж иржээ. Түүний нэг нь шинжлэх ухааны судалгааг тодорхойлогч янз бүрийн хэм хэмжээ, арга барилын цогц буюу аливаа мэдлэгийн эх сурвалж нь оюун ухаан гэж үздэг рационализм, нөгөө нь мэдлэгийн эх сурвалж нь мэдрэхүйн туршлага буюу шинжлэх ухааны ажиглалт, туршилтын үр дүн мөн гэж үздэг импиризм мөн. Үүнээс гадна «Сэтгүүл зүй нь нэг талаар бодит байдлыг танин мэдэх өвөрмөц хэлбэр бөгөөд түүний танин мэдэхүй нь рациональ ба уран сайхны арга юм»⁶ гэж үзэх судлаач ч байдаг. Нэг талаас сэтгүүл зүйд интертаймент чиглэл бодит үйл хэрэг болсон, нөгөө талаас нийтлэл нэвтрүүлэгт уран сайхны аргыг өргөн хэрэглэх уламжлалтай холбож үзвэл сэтгүүл зүйн практик үйл ажиллагаанд уран сайхны арга хэрэглэх нь байж болох зүйл билээ. Философтой адил хүмүүнлэгийн мэдлэг болохын хувьд дээрх аргуудын аль алийг сэтгүүл зүйд хэрэглэх бололцоотой юм.

Зарим судлаач сэтгүүл зүйн онол бол нийгэм-хүмүүнлэгийн ухааны “хавсарга” судлагдахуун гэж үзэх нь ч бий. Бас түүнийг үгүйсгэдэг хүмүүс ч

байдаг. Тийнхүү үгүйсгэгчид «Сэтгүүл зүй бол харилцааны үүрэг гүйцэтгэдэг нийгэм улс төрийн үйл ажиллагаа мөн» гэсэн зөв зүйтэй дүгнэлтээрээ сэтгүүл зүйг хавсарга биш бие даасан онол, шинжлэх ухаан гэсэн үзэл баримтлалтайгаа зөрчилддөг. Үнэхээр ч “үүрэг гүйцэтгэдэг”, “үйл ажиллагаа явуулдаг” онол байна гэхэд эргэлзээтэй юм.

Сэтгүүл зүй шинжлэх ухаан биш юм бол ядаж мэргэжил мөн үү? гэсэн асуулт гарч ирэх нь дамжиггүй. Яг үнэндээ сэтгүүл зүй шинжлэх ухаан мөн, биш гэж маргалдахаас илүү мэргэжил мөн үү, биш үү? гэж мэтгэлцэх нь амьдралд илүү ойр бөгөөд ашигтай юм. Тийм ч учраас сэтгүүл зүй мэргэжил мөн, эсэх тухай маргаан сэтгүүл зүйн эртний уламжлалтай, өндөр хөгжилтэй Өрнөдийн орнууд, түүний дотор Америкт хүчтэй өрнөсөн хэвээр байна.

Сэтгүүл зүйг мэргэжил биш гэж үзэгчдийн гол төлөөлөгч нь Америкийн сэтгүүл зүйн нэрт онолч Жон С.Меррилл мөн. Тэрээр сэтгүүл зүй мэргэжил биш гэж итгэлтэй хэлээд «Сэтгүүл зүй мэргэжил мөн гэдэг санааг батлах уламжлал маш бага байдаг. Ийм санаа нь зүгээр л сүүлийн үед гарч ирсэн чимэг төдий юм. Америкийн сэтгүүл зүйн түүхийн ихэнх үед сэтгүүл зүйг мэргэжил болгох асуудал чухал байгаагүй бөгөөд, хэрэв хэн нэгэн сэтгүүл зүйг юу гэж нэрлэх тухай асуудал гаргаж тавихад түүнийг зүгээр л худалдаа, гар урлал, эсвэл бусад ажил төрөлтэй адилтгаж үздэг байсан. Харин сүүлийн үед сэтгүүл зүйг мэргэжил гэж үзэх, түүнд тохирсон нэр томъёо, ойлголт бүтээх гэсэн хоосон гоё үг хэвлэл мэдээлэл, илтгэл яриагаар их тархсан юм. Саяхан би энэ үзэл санаанд сэтгэл зүрхээрээ элссэн нэгэн оюутантай ярилцаж үзэхэд

тэрээр “Би сэтгүүл зүйг мэргэжил гэж үзсэн учраас түүнд суралцахаар орсон” гэж эрс шийдэмгийгээр хэлсэн юм. Энэ нь сэтгүүлчид өөрсдийгөө “мэргэжлийн хүмүүс”, сэтгүүл зүйг “мэргэжил” гэж хэлүүлэх дуртай байдагтай холбоотой юм»⁷ гэсэн байдаг.

Ийм хандлага Монголын сэтгүүл зүйн хүрээнийхний дунд ч түгээмэл байдаг бөгөөд тэдний олонх нь сэтгүүл зүй мэргэжил мөн үү хэмээн эргэцүүлж үзээгүй хэрнээ зүгээр л “мэргэжил” гэж хэлээд хэвшчихсэн байдаг. Би зарим хүнд сэтгүүл зүй мэргэжил биш юм шиг байна гэсэн санааг цухалзуулахад ихэд дургүйцэж, идэж байгаа хоол руугаа буу шагайх хэрэггүй юм гэсэн утгатай үг хэлсэн. Энэ нь зүгээр л хийж байгаа ажил, дур сонирхолтой юмандаа хир халдаахгүй байх гэсэн хүн чанарын илрэл гэж бодоод өнгөрсөн билээ. Ганц энэ ч биш манайхан ерөнхийдөө “сэтгүүлч” гэдэг нэрэнд хүндэтгэлтэй, бүр бишрэнгүй хандаж, түүнээсээ сэтгэлийн таашаал авч байдаг юм шиг санагддаг. Магадгүй тэдний зарим нь хууль, анагаах зэрэг нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлүүдийг харж, дээд зиндааны гэгддэг тэдгээр мэргэжлийн хүмүүс бусдаас өндөр цалин орлоготой байгааг ажиглаад, өөрсдийн эрхэлдэг ажлыг тэр түвшинд хүргэх санааны үүднээс тийнхүү ханддаг байж болох юм. Жон С.Меррилл ийм хандлагыг «Олонх тохиолдолд ухаантнууд болон ухаантны дүр эсгэгчид байдаг сэтгүүлчид нь мэргэжлийн байх урхидалтыг маш хүчтэй хүлээж авдаг. Энэ нь тэдэнд хүндэтгэл хүлээх, олон нийтээр хүлээн зөвшөөрүүлэх, сүр хүч, эрх ямба бүхий орчинг, үгүйдээ наад зах нь жирийн сэтгүүлч байгаагаа үгүйсгэх гэсэн сэтгэл зүйн олдмол таашаалыг өгдөг»⁸ гэж нэлээд хоржоонтой хэлжээ. Тэрээр сэтгүүл зүйг

мэргэжил гэж төсөөлөх явдал Америкт өсч байгаа хэдий ч хувь сэтгүүлчид мэргэжлийн байх гэж чухам юуг хэлдэг, мэргэжлийн байх нь юунаас шалтгаалдгийг үнэн хэрэгтээ мэддэггүйг онцлон тэмдэглэсэн юм.

«Сэтгүүл зүйн тухай ярихад хэдийгээр ажил (vocation, calling and occupation) гэх мэт нэр хэрэглэдэг боловч тэр нь урлаг, эсвэл ямар нэгэн зүйл болно уу гэхээс мэргэжил гэсэн үг биш юм. Учир нь сэтгүүл зүй боловсролоос үл хамааран бүхэнд нээлттэй байдаг оршино. Сэтгүүл зүйд орох шалгуур, цогц мэдлэг, дур зоргоороо аашилдаг гишүүдэд шахалт үзүүлдэг дотоод элит бүлэг, ёс зүйн дүрэм, лицензийн тогтолцооны аль нь ч байддаггүй. Байгаа төрхөөрөө сэтгүүл зүй нь зарим талаар мэргэжилтэй адил ч, хараахан мэргэжил болж чадаагүй байна. Чадахад яарах ч хэрэггүй юм. Энэ тухайд хэвлэл мэргэжил болохын хэрээр авьяас чадвар, шинэ санаачилгыг боомилох нь ихсэж, хоёрдугаар зэргийн нөхдүүд л ахиж дэвшихийг дэмждэг болж хувирна гэсэн Лапхамын үзэлтэй санал нэгдэхэд хүрдэг. Ер нь сэтгүүл зүйг мэргэжил гэж үзэх нь олон урьгалч үзлийг үгүйсгэж, сэтгүүлчид олон нийтийн талаар бага бодож, өөрсдийн хувийн сонирхлыг дээгүүр тавих шалтгаан болно» гэж Жон С.Меррилл үзэж байна. Үүн дээр бас Америкт зөвхөн байгалийн ухааны салбаруудыг шинжлэх ухаан гэж, тэдгээрт мэргэжсэнийг “profession” буюу мэргэжил гэж албан ёсны баримт бичгүүдэд хүлээн зөвшөөрдөг бөгөөд бусад бүх ажил мэргэжлийг “art” буюу урлагт хамааруулж үздэгийг нэмж хэлэх нь илүүц болохгүй байх.

Сэтгүүл зүйг мэргэжил биш гэж үзэхийг дэмждэг хүмүүсийн нэг

төлөөлөгч нь Америкийн «Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн ёс зүй» сэтгүүлийн редактор, Алабамагийн Их Сургуулийн профессор Жей Блак юм. Тэрээр «Сэтгүүл зүйд мэргэжлийн байх нь» гэдэг өгүүлэлдээ бүр 1915 онд Авраам Флекснер боловсруулж, олон жилийн туршид стандарт тодорхойлолт болж ирсэн «Мэргэжлийн зургаан шинж чанар»-ыг шинжлэн дүгнэж үзээд сэтгүүл зүйд тэдгээр шинж чанарууд байдаггүй гэсэн дүгнэлтэд хүрчээ. Авраам Флекснерийн заасан тэрхүү зургаан шинж чанарыг товчлон үзүүлбэл: (1) мэдлэгийн өргөн цар хүрээтэй, адармаатай цогц бүрдэл; (2) зөвхөн юу, яаж гэх төдий бус тэрчлэн яагаад гэсэн онолын ухаан бүхий мэдлэг; (3) тодорхой, практик зорилт; (4) зорилго болон практикт шаардагдах боловсролын талаар бусад мэргэжилтнүүдтэй зөвшилцөх; (5) практикийн нийтлэг шалгуур, эсвэл стандарт-элсэлтийн шаардлагад тохирох; (6) энэрэнгүй, өөрийгөө дөвийлгөдөггүй, ашгийн сэдэлд үндэслэдэггүй байх зэрэг чанарууд аж.

Үүнээс гадна Америкийн Хөдөлмөрийн статистикийн товчооноос гаргасан мэргэжилд тавигдах түгээмэл шаардлагуудад *нэгд*: тогтоосон боловсролын стандартууд, *хоёрт*: лиценжүүлэлт, *гуравт*: мөрдөх гүйцэтгэлийн стандартуудыг жагсаасан байдаг.

Мэргэжил мөн, эсэхийг таних дээрх шинж чанаруудыг авч үзсэний үндсэн дээр Жей Блак сэтгүүл зүй хэдийгээр мэргэжлийн зарим шинжийг агуулдаг, эсвэл зарим талаараа мэргэжилд дөхөж очдог хэдий ч илэрхийгээр энэ нь мэргэжил биш юм гэсэн дүгнэлт гаргаад, түүнийгээ батлахын тулд «Бид илжиг нь морьтой адилхан олон шинжийг агуулдаг, тэр шинжээрээ моринд

ихээхэн дөхөж очдог гэж хэлж болно. Гэвч бид илжиг бол морь биш гэдгийг маш тодорхой хэлэх ёстой»⁹ гэсэн сонирхолтой зүйрлэлийг ашигласан байдаг. Сэтгүүл зүйг мэргэжил биш гэж үздэг судлаачид бас дараах үндэслэлийг хэлдэг. Тэр нь *Нэгд*: сэтгүүлчид болон тэдгээрийн үйлчлүүлэгчдийн хооронд шууд холбоо байдаггүй. *Хоёрт*: сэтгүүлчид нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүс биш бөгөөд ямар нэгэн ажил олгогчид хүчин зүтгэдэг. *Гуравт*: сэтгүүл зүйд ороход албан ёсны хамгийн наад захын шаардлага гэж байдаггүй. Өөрийг нь ажилд авч л байгаа бол хэн ч сэтгүүлч байж болно. Туршлагатай туршлагагүй, зэрэгтэй зэрэггүй нь хамаагүй. *Дөрөвт*: ямар ч сэтгүүлч ёс зүйн дүрэмд захирагдах шаардлагагүй. АНУ-д л гэхэд ямар ч сэтгүүлч гэрчилгээжиж, лицензжээгүй. *Таавд*: сэтгүүлчдэд нийтээр хүлээн зөвшөөрч мөрддөг мэргэжлийн ямар ч стандарт байдаггүй. «*National Enquirer*»-т ажиллаж байгаа хүн «*New York Times*»-д ажиллаж байгаа хүнтэй адилхан л сэтгүүлч. «*Podunk Weekly Bugle*»-д ажиллаж байгаа хүн «*Wall Street Journal*»-д ажиллаж байгаа хүнтэй адилхан л сэтгүүлч гэгддэг, *Зургаад*: сэтгүүлчид нийтлэг “дээд түвшний ерөнхий болон системчилсэн мэдлэг”-ийг хуваалцдаггүй. Тэдэнд өөрийн ажлын ур чадвараар (бүгдийг бусад мэргэжлийн чиглэлээс авсан) дадлагажих онцгой эрх байдаггүй. Эцэст нь хэлэхэд Америкийн сэтгүүлчид “нэг төрлийн нийгмийн бүлэг”-ийг бүрдүүлдэггүй зэрэг болно.

Орчин үеийн тайлбарлагч Ирвинг Кристолийн үгийг сонсоё. Тэрээр «Өнөө үед сэтгүүл зүй мэргэжил болох тухай ярих нь хэтэрхий нялцгануур зүйлээр хөөцөлдөж байгаа хэрэг.

Сэтгүүл зүй нь одоогоор мэргэжлийн хамгийн энгийн шинж тэмдгийг ч олж авч чадаагүй байна» гэжээ. Сэтгүүл зүй хэдийгээр мэргэжил биш ч гэсэн тэр нь ёс зүйн дүрмийн хатуу шаардлага, хэвлэлийн зөвлөл, тэгш эрхт шахалт, зарим төрлийн лиценз, элсэлтийн шаардлага болон сэтгүүл зүйн боловсролын илүү чанга стандарт зэргээр дамжин жинхэнэ мэргэжил болж чадах ёстой аж. Ирвинг Кристоль «Би сэтгүүл зүй мэргэжил болох бололцоогүй гэж маргалдаагүй, тэр нь одоохондоо болоогүй байна. Гэвч мэргэжил болж хувирах нь хүсүүштэй зүйл биш гэж боддог» гэжээ.

Америкийн тэргүүлэх социологичдын нэг Уиллиам Гүүдэ мэргэжилтнүүд үнэт зүйл, хувь шинж, үүрэг болон сонирхлоо хуваалцдаг гишүүдтэй нэг төрлийн (гомоген) нийгмийн бүлгийг бүрдүүлдэг гэсэн үндэслэлээ шаргуу хамгаалдаг нэгэн юм. Тэрээр хэлэхдээ «Аливаа мэргэжлийн гишүүд хувь шинжийн мэдрэмжээрээ холбогдож, нийтлэг үнэт зүйлсээ хуваалцаж байдаг» гэсэн билээ. Ийм шинж сэтгүүл зүйн хүрээнд харьцангуй сул байдаг нь бидний санааг тэтгэх бас нэг үндэслэл болох юм.

Сэтгүүл зүй мэргэжил биш гэж үзэх бидний санааг философич Уиллям Баррет судалгааны бүтээлдээ маш эерэгээр тодорхойлж «Мэргэжилтэй болохын тулд төлж буй үнэ цэн нь *deformation professionelle* буюу Францаар мэргэжлийн гажуудал юм. Эмч болон инженерүүд юмсыг өөрсдийн мэргэжлийн үүднээс харах хандлагатай байдаг бөгөөд энэхүү бүсээс гадна байгаа зүйлсийг огт хардаггүй. Мэргэших тусам харааны төвлөрөл улам нарийсч, тэр хэрээр энэхүү төвлөрлөөс гаднах зүйлсийг харж

чадахгүй болох нь улам нэмэгддэг» гэсэн юм. Энэ нь угтаа сэтгүүл зүй мэргэших тутам хуулийн заалт шиг хатуу хэвэнд орж, амьдралыг өөр өөр талаас нь харж, уран сэтгэх чадвар нь хумигдана гэсэн санаа байна.

Судлаач Лювис Лапхам хэвлэлийн салбарынхны дунд ямар нэгэн сонгосон бүлэгт (түүний нэрлэснээр “хэвлэлийнхний шаталсан тогтолцооны хүсэл” гэх мэт) хамрагдах сонирхол гүнзгий суусан байдаг тухай өгүүлээд «Хэрэв энэ хандлага цааш хэт их үргэлжилбэл хэвийн бус, хачин ойлголт бий болгож, улмаар түүнийг тосон авах сэтгүүлчдэд ч нөлөөлөх нь надад тодорхой харагдаж байна. Хэвлэл мэргэжил болохын хэрээр “авьяаслаг омголон сонирхогчдоо эгнээндээ нэгтгэхээс татгалзах” нь ихсэж, бусад мэргэжлийн нэгэн адилаар “хоёрдугаар зэргийн” дундаж нөхдүүд л ахиж дэвших боломжтой болж хувирна» хэмээн бичжээ. Нөгөө талд мэргэжлийн байх нь сэтгүүл зүйн зэрэглэлийг хязгаарлаж, “мэргэжлийн бусчууд”-ыг шахан гаргаж, хэвлэлийг илүү нэр хүндтэй болгоно гэдэг үзэл нь мэргэжлийг бүрдүүлж буй элитүүдийн үүднээс авч үзвэл огт эргэлзээгүй зүйл юм.

Мэргэжил болсноор олон талт байдал алдагдаж, асуудлыг өөр өөр өнцөг, өнгө аясаар харах чадвар буурна гэсэн болгоомжлол дээр нэмээд, сэтгүүл зүй мэргэжил байх ёсгүйн бас нэг шалтгааныг Иллинойсын Их сургуулийн Харилцааны Коллежийн декан Жеймс Карей олон арга хэмжээн дээр учирлан тайлбарласаар иржээ. Тэрээр «Хэрэв сэтгүүл зүй мэргэжил байсан бол түүнийг эзэмшигчид өөрсөд рүүгээ хэт чиглэн сэтгүүл зүйг биеэ хамгаалах механизм, хувийн эрх ашигтаа илүү их анхаарах хэрэгсэл болгож, улмаар

олон түмний өмнө хүлээсэн үүргээ умартах болно. Хамт олны дунд өөрсдөөрөө бахархах, биеэ тоосон бардам сэтгэлийн халдвар тархсанаар мэргэжлүүд хувиа хичээж, амиа бодсон байдалтай болдог гэдэгт би итгэлтэй байна» гэсэн байна. Карейтай санал нийлэгчид олон байдаг аж. Хэрэв улс орны хамгийн олон талт, нээлттэй институтуудын нэг бөгөөд, их төлөв олон нийтийн үйлчилгээнд зориулагдсан сэтгүүл зүй нь тулга тойрсон, нэг янзын, өөртөө төвлөрсөн, бусадтай харилцаа холбоо тогтоох хүсэл бүхий үйлчилгээний баримжаагүй хамтын нийгэмлэг болж хувирвал ихээхэн өрөвдөлтэй болно гэж тэд үздэг байна. Тиймээс ч тэд сэтгүүл зүй нь мэргэжил биш бөгөөд, байх ч ёсгүй гэсэн үзэл баримтлалдаа үнэнч байдаг аж.

Энэ өгүүллийг бичигч бид сэтгүүл зүй шинжлэх ухаан биш, мэргэжил ч биш, гагцхүү хүмүүнлэгийн мэдлэг мөн гэсэн үзэлдээ хөтлөгдөн асуудалд зөвхөн нэг талаас нь хандахын эсрэг байгаа билээ. Тэр ч үүднээс сэтгүүл зүй өндөр хөгжсөн улсууд, тэр тусмаа Америкт сэтгүүл зүйг мэргэжил мөн гэж үздэг судлаачид ч бас байдгийг дурдах нь зүйтэй.

Ингэж үздэг эрдэмтний нэг нь Эверетт Е.Деннис юм. Тэрээр Жон С. Меррилл тэргүүтэй эрдэмтдийн үзлийг сөргүүлж бичихдээ «Сэтгүүл зүй нь мэргэжлийн бүгд биш юмаа гэхэд гол гол шинж тэмдгүүдийг өөртөө агуулдаг тул энэ ангилалд багтах эрхтэй. Энэ бодомж нь түгээмэл хэллэгт (“мэргэжлийн” жүжигчин, “мэргэжлийн” тамирчин гэх мэт) цоорхой үүсгэхгүй бөгөөд, харин мэргэжлийг худалдаа эсвэл ажил мэргэжлээс ялгах гол шалгуурууд нь Америкийн сэтгүүл зүйд салшгүй нэг хэсэг нь байдгийг тодотгодог. Бусад мэргэжлийн адилаар сэтгүүл зүй нь

мэргэжлийн шинж чанарыг өөр өөр эрчимтэйгээр үзүүлдэг»¹⁰ гэсэн юм.

Тэрээр ямарваа мэргэжлийн үндсэн шинжүүдийн нэг бол “олон нийтийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх үндсэн зорилготой нэг төрлийн ажил” байх ёстой. Сэтгүүл зүй нь АНУ-д Анхдагч Нэмэлт өөрчлөлтөд туссан эрх чөлөөний гол цөм болсон мэдээлэл болон үзэл бодлын чөлөөт урсгалаар дамжин олон нийтийн үйлчилгээнд оролцдог. Хэвлэлийг Үндсэн хуулиар тусгайлан хамгаалдаг нь зөвхөн сонин хэвлэл, өргөн нэвтрүүлгийн эздэд ашиг олох боломж олгох төдий бус, харин хууль болон нийгмийн бодлогын асуудал байдаг учраас чөлөөт хэвлэл нь ардчилал оршин байхын гол нөхцөл гэдэгт итгүүлдэг юм. Мэдээж хэвлэл өөрөө оршин байх, сэтгүүлч, редакторууд хийсэн ажлынхаа төлөө цалин болон олон төрлийн урамшуулал авч байхын тулд ашиг олох хэрэгтэй. Тэдний олонх нь өөрсдийгөө олон нийтийн үйлчилгээнд зүтгэдэг гэж маргадаг нь үндэслэлтэй юм. Хууль, анагаах, архитектур болон бусад мэргэжлүүд олон нийтийн үйлчилгээнд оролцохын сацуу эдгээрийг эзэмшигчдийн амьдралыг хангадаг нь тодорхой юм. Ингэснээр тэднийг мэргэжилтний эгнээнээс нь хасдаггүй. Хамгийн хатуу тодорхойлолтоор авч үзвэл зөвхөн санваартан, тэгэхдээ хамгийн дээд зэргээр бэлтгэгдсэн санваартан л мэргэжилтэн байж магадгүй юм.

Мэргэжлийг хамгийн энгийнээр тодорхойлбол “тусгай мэдлэг, урт хугацааны эрчимтэй бэлтгэл” болон “олон нийтийн үйлчилгээнд оролцдог” байх явдал юм. Сэтгүүл зүй нь үүсэх үедээ мэргэжил байсан эхэсээс үл хамааран энэ нь мэргэжил болон хувирч (анагаах, хуулийн адилаар) болохыг би үгүйсгэхгүй. Мэдээллийн

чөлөөт урсгалыг хангадгаараа сэтгүүл зүй нь олон нийтийн үйлчилгээнд оролцдог. Тэрчлэн Мерриллийн гаргасан хуучны шалгуураар сэтгүүл зүй нь мэргэжлийн зохион байгуулалтын шинж чанар, экспертиз, болон бодитоор орших чанарыг агуулж чаддаг. Сэтгүүлчид өргөн хүрээний мэдлэгтэй байх ёстой гэдэг үүднээс авч үзвэл тусдаа бие даасан цогц мэдлэгтэй байх шаардлагатай. Бас сэтгүүл зүйн сургуулиудад стандарт сургалтын хөтөлбөр байдаг. Аль нэг салбарыг мэргэжил гэж авч үзэхэд эзэмшигчдийн нь нэгэн жигд байдал шаардлагагүй юм. Олон тооны эмч, хуульчид өөрсдийн зорилгоо харилцан адилгүй ухамсарладаг. Социологийн цэцэрхэгчид цэвэр тодорхойлолтоос нь гадуурх дутагдлыг бүх мэргэжлээс олж чадна, гэхдээ бүх практик зорилгын үүднээс бол сэтгүүл зүй нь мэргэжил юм гэсэн үндэслэлүүдийг гаргаж тавьсан байдаг.

Эцэст нь дүгнэж хэлэхэд сэтгүүл зүй бол шинжлэх ухаан биш, мэргэжил ч биш, харин ихэнх тохиолдолд үнэлэмжид хандсан хүмүүнлэгийн мэдлэг юм. Мэргэжлийн сургуулийг нь төгсөөгүй хэн ч барьж аваад хийчихдэг ажлыг мэргэжил гэх боломжгүй. Харин би сэтгүүл зүй мэргэжил болж чадахгүй гэж хэлэхгүй. Мэргэжлүүдэд байдаг тогтолцоот мэдлэгийг төгс бүрдүүлж, өөрийн гэсэн хууль, категоритой болсон цагт тэр нь мэргэжил болж болох юм. Сэтгүүл зүй тэр шат руу дөтөлсөөр байгаа. Энэ үзэл баримтлалдаа дэмжлэг авахын тулд би сэтгүүл зүй өндөр хөгжсөн орнуудын тэргүүлэх эрдэмтдийн бүтээлээс иш татсан болно.

Ишлэл

¹ Прохоров Е. П. 1995. Введение в теорию журналистики. М., с. 107-108.

² *Далёз Жиль, Гваттари Феликс*. 1998. Что такое философия? СПб., с. 100.

³ *Гомбосүрэн Ц.* 2014. Өнөөгийн манайхан философийн (гүн ухааны) түүхээ үнэн зөв бичиглэдэг үү? (маргаан ба судалгаа). УБ., 155-156 дахь тал.

⁴ *Платон*. 1968. Сочинения в 3-х томах. Т. 1. М., с. 417.

⁵ *Аристотель*. 1975. Сочинения в 4-х томах. Т. 1. М., с. 141.

⁶ *Зулькафиль М.* 2014. Сэтгүүл зүйн ерөнхий онолыг боловсруулах онол-арга зүйн асуудалд. «Сэтгүүл зүй» МУИС-ийн ЭШБ. № 15 (417).

⁷ *Merrill John C.* 1991. «Journalism Is Not a Profession». Media Debates: Issues In Mass Communication, p. 11.

⁸ Дурд. зох., р. 12.

⁹ Мөн тэнд.

¹⁰ *Dennis Everett E.* 1991. «Journalism Is a Profession». Media Debates: Issues In Mass Communication, p.14.

5. *Гомбосүрэн Ц.* 2014. Философи. УБ.

6. *Далёз Жиль, Гваттари Феликс*. 1998. Что такое философия. СПб.

7. *Зулькафиль М.* 2014. Сэтгүүл зүйн ерөнхий онолыг боловсруулах онол-арга зүйн асуудалд. «Сэтгүүл зүй» МУИС-ийн ЭШБ. №15 (417).

8. *Кун Т.* 1975. Структура научных революций. М.

9. *Норовсүрэн Л.* 2012. XX зууны эхэн үеийн монгол сэтгүүлчид. УБ.

10. *Платон*. 1968. Сочинения в 3-х томах. Т. 1. М.

11. *Прохоров Е. П.* 1995. Введение в теорию журналистики. М.

12. *Прохоров Е. П.* 2006. Исследуя журналистику. М.

13. *Фомичева. И. Д.* 2011. Основные этапы процедуры эмпирического исследования. Исследования СМИ: методология, подходы, методы. М.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Dennis Everett E.* 1991.«Journalism Is a Profession» Media Debates: Issues In Mass Communication.

2. *Merrill John C.* 1991. «Journalism Is Not a Profession» Media Debates: Issues In Mass Communication.

3. *Аристотель*. 1975. Сочинения в 4-х томах. Т. 1. М.

4. *Гомбосүрэн Ц.* 2014. Өнөөгийн манайхан философийн (гүн ухааны) түүхээ үнэн зөв бичиглэдэг үү? (маргаан ба судалгаа). УБ.

Резюме

В настоящей статье автор анализирует теоретические концепции о журналистике и на основании выявления специфических черт деятельности масс-медиа затрагивает следующий вопрос: журналистика — это наука, а журналист — это профессия? Кроме того, автор полемизирует на тему что представляет собой журналистика: научное или гуманитарное знание. При этом автор опирается на мысли и положения известных американских учёных Д.Меррилла и Денниса.